

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын ГЭРЧИЛГЭЭ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	6
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3. Менежментийн захидал	8
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	9
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	9
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	10
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	11
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	12
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

1008 АЙЛЫН ТҮР СУУРЬШУУЛАХ
ОРОН СУУЦНЫ ТӨСӨЛ
ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Л.ГАНБААТАР ТАНАА

2020.02.27 № 06/619
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг 1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч Л.Ганбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой холбогдох заавар журмыг мөрдөж ажиллах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 3-наас 2020 оны 2 дугаар сарын 19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Энич Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн А/19 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 1008 айлын орон сууцны хотхоныг ил болон далд авто зогсоол, гадна дотор инженерийн барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, дэд өртөөний хамт барихад оршино.

1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- БНХАУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжих төсөл арга хэмжээнд 1008 айлын орон сууцны барилга, байгууламжийн захиалагчийн техникийн хяналт тавих;
- Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаатай уялдаатай төрийн байгууллагуудын харилцан уялдаа холбоог зохицуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус 1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгжийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгж нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous 3.0” програм хангамж ашигладаг байна.

1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгжийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар 1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгжийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 15 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 395,829.6 мянган төгрөгөөс тооцон 7,916.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон материаллаг байдлын суурь үзүүлэлтийн дүн, материаллаг байдлын хувь хэмжээ гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөгдөөгүй болно.

2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгж нь Сангийн сайд, Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан 2019 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 27/30 тоот тушаалаар байгуулагдсан. Тус төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 385,366.3 мянган төгрөг байна. Үүнд: мөнгөн хөрөнгө 166.3 мянган төгрөг, урьдчилж гарсан зардал 138,000.0 мянган төгрөг, бараа материал 15,215.1 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 231,985.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Мөн урьдчилж орсон орлого 3,030.3 мянган төгрөг, засгийн газрын оролцоо 382,336.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.9. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрт зориулан 600,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан. Нийт төсвийг урсгал зардалд зарцуулах ба зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 544,144.1 мянган төгрөг буюу 90.7 хувьтай байгаа нь төлөвлөсөн төсөл арга хэмжээ хэрэгжээгүйн улмаас бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамж болон бараа үйлчилгээний бусад зардлаас 55,855.9 мянган төгрөгийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 15 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 18 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 7,131.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 7,131.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн дараах 7,131.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Гэрээт ажилтнуудын ажлын хөлсийг төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын тогтоосон жишиг цалингаас 7,131.6 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон нь Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 6 дугаар хавсралт “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын ажлын хөлсний жишиг”, Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 9.1.6-д “Гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын ажлын хөлсний жишиг загвар” маягтад үндэслэн ТХН-ийн ажилтнуудын болон шаардлагатай тохиолдолд бие даасан зөвлөхийн цалинг тогтоон батлах” гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байдал, хэмжилт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага

2. Төслийн барилга барих газрын нөлөөлөлд өртсөн иргэдэд газар, үл хөдлөх хөрөнгийн нөхөх олговрыг тус төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны төсвийн урсгал зардлаас зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Газрын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.2-т заасан Засгийн газрын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг дарга иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан тухайн газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авна”, мөн Засгийн газрын 2018 оны 222 дугаар тогтоолоор батлагдсан “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны нөхөх олговор олгох журам”-ын 5.2-т “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан олгох нөхөх олговрыг аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга хариуцах ...” гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага

Аудитаар илэрсэн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХҮЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгиж шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал болон анхаарал татсан асуудал гараагүй.

2.12. Шилэн дансны мэдээлэл

1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгж Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 63 мэдээллийг хугацаанд нь, 18 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгж нь тайлант онд шинээр үүсгэн байгуулагдсан тул аудит хийгдэж байгаагүй болно.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Биет бус хөрөнгийн элэгдлийг тооцоогүй. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх дансны заавар"-ын 4.49-д "Биет бус хөрөнгийг түүний үр ашигтай ашиглах хугацааны туршид системтэйгээр хорогдуулж, хорогдлын хэмжээгээр зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Биет бус хөрөнгийг зөвхөн шулуун шугамын аргаар элэгдүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байдал, хэмжилт, үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Биет бус хөрөнгийн элэгдүүлэлт, хорогдуулалтыг буруу тооцсон байх

1.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх дансны заавар"-ын холбогдох заалтыг хэрэгжүүлж, биет бус хөрөнгийг түүний үр ашигтай ашиглах хугацааны туршид системтэйгээр хорогдуулж, хорогдлын хэмжээгээр зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэх

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчлийг байгууллагын дарга, нягтлан бодогч нар хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	-	153,381,373.35
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	166,293.35
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	17,793.35
31140	Касс арилжааны банк	-	17,793.35
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	148,500.00
3121	Төгрөг	-	148,500.00
31211	Төрийн сангийн харилцах	-	148,500.00
34	УРЬДЧИЛГАА	-	138,000,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	138,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	-	15,215,080.00
354	Хангамжийн материал	-	15,215,080.00
35410	Бичиг хэргийн материал	-	1,014,650.00
35420	Аж ахуйн материал	-	11,397,890.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	460,000.00
35470	Бусад хангамжийн материал	-	2,342,540.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	231,985,014.64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	231,985,014.64
392	Биет хөрөнгө	-	230,205,014.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	178,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,483,333.33)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	36,733,504.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(2,879,584.37)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	20,217,547.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(662,118.66)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	324,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(45,000.00)
393	Биет бус хөрөнгө	-	1,780,000.00
39301	Програм хангамж	-	1,780,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	-	385,366,387.99
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	3,030,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	3,030,000.00
413	Өглөг	-	30,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	30,000.00
414	Урьдчилж орсон орлого	-	3,000,000.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	-	3,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	382,336,387.99
51	Засгийн газрын хувь оролцоо	-	382,336,387.99
512	Хуримтлагдсан үр дүн	-	382,336,387.99
51220	Тайлант үеийн үр дүн	-	382,336,387.99
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	-	385,366,387.99

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	778,166,293.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	178,166,293.35
120	Нийтлэг татварын бус орлого	-	178,166,293.35
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	178,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	178,000,000.00
120009	Бусад орлого	-	166,293.35
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	600,000,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	600,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	600,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	395,829,905.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	339,974,004.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	339,974,004.09
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	25,556,237.76
210201	Тэтгэврийн даатгал	-	21,570,891.44
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,072,775.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	858,220.86
210204	Ажилгүйдлийн даатгал	-	182,398.72
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,871,951.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	26,035,600.00
210304	Байрны түрээс	-	26,035,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	3,747,740.00
210401	Бичиг хэрэг	-	2,089,420.00
210402	Тээвэр, шатахуун	-	90,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,568,320.00
2107	Томилолт, зочны зардал	-	13,393,250.00
210701	Гадаад албан томилолт	-	7,554,616.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	5,838,634.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	265,999,099.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	265,999,099.97
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,242,076.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	172,040.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	5,070,036.36
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	55,855,901.27
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	55,855,901.27
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	55,855,901.27
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	382,336,387.99
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	382,336,387.99

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	603,166,293.35
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	3,166,293.35
120	Нийтлэг татварын бус орлого	-	3,166,293.35
120009	Бусад орлого	-	3,166,293.35
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	600,000,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	600,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	600,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	603,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	603,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	547,144,098.73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	22,926,000.00
210201	Тэтгэврийн даатгал	-	22,926,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	26,035,600.00
210304	Байрны түрээс	-	26,035,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	7,397,340.00
210401	Бичиг хэрэг	-	5,082,820.00
210402	Тээвэр, шатахуун	-	746,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	1,568,320.00
2105	Нормативт зардал	-	648,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	648,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	56,200,851.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	33,282,200.00
210602	Тавилга	-	22,918,651.00
2107	Томилолт, зочны зардал	-	13,393,250.00
210701	Гадаад албан томилолт	-	7,554,616.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	5,838,634.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	418,833,737.73
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	418,833,737.73
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,709,320.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,709,320.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	55,855,901.27
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	55,855,901.27
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	55,855,901.27
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	166,293.35
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	166,293.35
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	166,293.35

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	382,336,387.99	382,336,387.99
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	382,336,387.99	382,336,387.99

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	600,000,000.00	544,144,098.73	55,855,901.27	90.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	600,000,000.00	544,144,098.73	55,855,901.27	90.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	600,000,000.00	544,144,098.73	55,855,901.27	90.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,926,000.00	22,926,000.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	22,926,000.00	22,926,000.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,226,000.00	26,035,600.00	190,400.00	99.3
210304	Байрны түрээс	26,226,000.00	26,035,600.00	190,400.00	99.3
2104	Хангамж, бараа материалын зардал	8,932,500.00	7,397,340.00	1,535,160.00	82.8
210401	Бичиг хэрэг	5,586,300.00	5,082,820.00	503,480.00	91.0
210402	Тээвэр, шатахуун	1,520,200.00	746,200.00	774,000.00	49.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,826,000.00	1,568,320.00	257,680.00	85.9
2105	Нормативт зардал	2,430,000.00	648,000.00	1,782,000.00	26.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,430,000.00	648,000.00	1,782,000.00	26.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58,216,600.00	56,200,851.00	2,015,749.00	96.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	33,500,000.00	33,282,200.00	217,800.00	99.3
210602	Тавилга	24,716,600.00	22,918,651.00	1,797,949.00	92.7
2107	Томилолт, зочны зардал	13,393,300.00	13,393,250.00	50.00	100.0
210701	Гадаад албан томилолт	7,554,616.00	7,554,616.00	-	100.0
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,838,684.00	5,838,634.00	50.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	465,925,600.00	415,833,737.73	50,091,862.27	89.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	465,925,600.00	415,833,737.73	50,091,862.27	89.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,950,000.00	1,709,320.00	240,680.00	87.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,950,000.00	1,709,320.00	240,680.00	87.7
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	600,000,000.00	544,310,392.08	55,689,607.92	90.7
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	600,000,000.00	544,144,098.73	55,855,901.27	90.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	600,000,000.00	544,144,098.73	55,855,901.27	90.7
120009	БУСАД ОРЛОГО	-	166,293.35	(166,293.35)	
1200091	Бусад орлого	-	166,293.35	(166,293.35)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		166,293.35	(166,293.35)	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	15	11	4	73.3
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	14	10	4	71.4

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2019.02.17			САГ-2020/701/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгж		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Гэрээт ажилтнуудын ажлын хөлсийг төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын тогтоосон жишиг цалингаас 7,131.6 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон.	7,131.6	Албан шаардлага өгөх	Төслийн зохицуулагч, санхүүгийн ажилтан	Л.Ганбаатар, Т.Жавзандулам
2	Төслийн барилга барих газрын нөлөөлөлд өртсөн иргэдэд газар, үл хөдлөх хөрөнгийн нөхөх олговрыг тус төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны төсвийн урсгал зардлаас зарцуулсан.		Албан шаардлага өгөх	Төслийн зохицуулагч, санхүүгийн ажилтан	Л.Ганбаатар, Т.Жавзандулам
3	Биет бус хөрөнгийн элэгдлийг тооцоогүй.		Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч, санхүүгийн ажилтан	Л.Ганбаатар, Т.Жавзандулам
	Нийт	7,131.6			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 03

№ 02/68

Улаанбаатар хот

с.т. 2020/701/СТД-Т.Х.Н.

Г Зөрчил арилгуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Гэрээт ажилтнуудын ажлын хөлсийг төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын тогтоосон жишиг цалингаас 7,131.6 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журам”-ын 9.1.6-д “Гадаадын тусламжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын ажлын хөлсний жишиг загвар” маягад үндэслэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын болон шаардлагатай тохиолдолд бие даасан зөвлөхийн цалинг тогтоон батлах”, Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 6 дугаар хавсралт “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын ажлын хөлсний жишиг”-тэй тус тус нийцэхгүй байна.

2. Төслийн барилга барих газрын нөлөөлөлд өртсөн иргэдэд газар, үл хөдлөх хөрөнгийн нөхөх олговрыг тус төсөл хэрэгжүүлэх нэгжийн 2019 оны төсвийн урсгал зардлаас олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Газрын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.2-т заасан Засгийн газрын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг дарга иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан тухайн газрыг нөхөх олговортойгоор солих буюу эргүүлэн авна”, мөн Засгийн газрын 2018 оны 222 дугаар тогтоолоор батлагдсан “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны нөхөх олговор олгох журам”-ын 5.2-т “Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 14.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан олгох нөхөх олговрыг аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга хариуцах ...” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.






\\10.10.10.20\Richie_Kheree\Alban Shaardlaga\2020\03025AG2.Docx

001080148

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...” Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1 дэх заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн гэрээт ажилтнуудын болон шаардлагатай тохиолдолд бие даасан зөвлөхийн цалинг холбогдох журмаар батлагдсан “Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын ажлын хөлсний жишиг загвар”-т үндэслэн тогтоох,
2. Төслийн барилга барих газрын нөлөөлөлд өртсөн айл өрхүүдэд газар, үл хөдлөх хөрөнгийн нөхөх олговор олгох зардлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.

Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг 1008 айлын түр суурьшуулах орон сууцны төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч Л.Ганбаатар, санхүүгийн ажилтан Т.Жавзандулам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ	
ӨГСӨН: САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ АУДИТОР  О.БАЯРМАА ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧ: ЭНИЧ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР:  Н.НАРАН	ЗӨВШӨӨРСӨН: 1008 АЙЛЫН ТҮР СУУРЬШУУЛАХ ОРОН СУУЦНЫ ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН ЗОХИЦУУЛАГЧ  Л.ГАНБААТАР САНХҮҮГИЙН АЖИЛТАН  Т.ЖАВЗАНДУЛАМ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу харцуцагч албан тушаалтанд харцуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

